

**НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ХУУЛИЙН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 12 дугаар
сарын 9-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга, О.Батнайрамдал нарын зүгээс 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2025 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдаанаараа хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс урьдчилан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллуудыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.17 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр санал хураалт явууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг “Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй, хуулийн төслийн 2 дугаар зүйлийг хасах, мөн хамт өргөн мэдүүлсэн Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.


Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин хуулийн төслийн 1 дүгээр зүйлийг “нийтээр тэмдэглэх баярын өдөр долоо хоног бүрийн амралтын өдөртэй давхацсан тохиолдолд давхацсан өдрийг дараагийн ажлын өдөр шилжүүлэх, төслийн тайлбар хэсгийг хасах гэсэн найруулгын санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**


Ц.САНДАГ-ОЧИР

**НЭГ.НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн найруулгын санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийн “нийтээр амрах” гэснийг “долоо хоног бүрийн амралтын” гэж өөрчилж, “давхацсан бол” гэсний дараа “давхацсан өдрийг” гэж нэмж, төслийн Тайлбарыг хасах.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин

**ХОЁР.НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ТАЛААРХ ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн 2 дугаар зүйлийн “баталсан” гэснийг “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон” гэж өөрчлөх.

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга

**ГУРАВ.НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээгүй санал:

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баяр, Цагаан сар тухайн долоо хоногийн амралтын өдрүүдтэй давхацсан тохиолдолд дараагийн долоо хоногийн ажлын өдрүүдэд шилжүүлэн амарна.”

Санал гаргасан: Улсын Их Хурлын гишүүн Б.Уянга

---oOo---